

**ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД БА ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧДАД ЗОРИУЛСАН
КОРОНАВИРУС 2019 (КОВИД-19) ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ПФАЙЗЕР-БИОНТЕК КОВИД-19 ВАКЦИН, ПФАЙЗЕР-БИОНТЕК КОВИД-19,
БИВАЛЕНТ ВАКЦИН (ЭХ ХУВЬ БА ОМИКРОН ВА.4/ВА.5) ВАКЦИНЫ
ТУХАЙ МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС
5-ААС 11 НАСНЫ ХАМРАХ ХҮРЭЭ**

5-ААС 11 НАСНЫХАНД

Таны хүүхдэд SARS-CoV-2 коронавирусаар халдварладаг Коронавирус 2019 (КОВИД-19) өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Пфайзер-БионТек КОВИД-19 вакцин¹ эсвэл

Пфайзер-БионТек КОВИД-19, Бивалент вакцин (Эх хувь ба Омикрон ВА.4/ВА.5, ²цаашид "Пфайзер-БионТек КОВИД-19, Бивалент вакцин" гэх)-ыг санал болгож байна.

Энэхүү Үйлчлүүлэгч ба Эрүүл Мэндийн ажилтнуудад зориулсан Вакцины Мэдээллийн Хуудас нь зөвшөөрөлтэй Пфайзер-БионТек КОВИД-19 Вакцин^{3,4} болон Пфайзер-БионТек КОВИД-19, Бивалент вакциныг 5-аас 11 насны хүмүүст хэрэглэх мэдээллийг багтаасан.

Пфайзер-БионТек КОВИД-19 вакцин нь АНУ-ын Хүнс, Эмийн Захиргаанаас (FDA) Яаралтай хэрэглэх зөвшөөрөл (EUA)-ийг доорх нөхцөлтэй авсан:

- **5-аас 11 настай хүүхдэд хийх анхан шатны цувралын 2 тун.**
- **тодорхой төрлийн дархлаа султай болох нь тогтоогдсон 5-аас 11 настай хүүхдэд хийх анхан шатны цувралын гурав дахь тун.**

¹Моновалентын вакцин болох Пфайзер-БионТек КОВИД-19 вакцин нь зөвхөн анхны SARS-CoV-2-ын баяжуулалтын уургийг кодолдог.

²Пфайзер-БионТек КОВИД-19 вакцин нь зөвхөн анхны SARS-CoV-2 болон Омикрон ВА.4/ВА.5 SARS-CoV-2-ын баяжуулалтын уургийг кодолдог.

³Таны хүүхэд 4 настай байсан ч та энэхүү мэдээллийн хуудсыг хүлээн авах боломжтой. 3 Хэрэв таны хүүхэд дараагийн 11 долоо хоногт 5 нас хүрэх бөгөөд анхан шатны цувралаа хийлгэж эхлээгүй бол та хүүхдээ дараах байдлаар вакцинд хамруулах боломжтой: (1) 5-аас 11 нас хүртэлх хүмүүст хэрэглэхийг зөвшөөрсөн Пфайзер-БионТек КОВИД-19 вакцины 2 тунгийн анхан шатны цуврал; (2) 6 сараас 4 нас хүртэлх хүүхдэд 1 ба 2 тунгаар хэрэглэхийг зөвшөөрсөн Пфайзер-БионТек КОВИД-19 вакцины 3 тун болон Пфайзер-БионТек КОВИД-19, Бивалент вакцин 3. Сонголтуудыг үйлчилгээ үзүүлэгчтэйгээ ярилцана уу.

⁴Таны хүүхэд 12 настай байсан ч та энэхүү Мэдээллийн хуудсыг авч болно. 11-12 хүртэлх насны хүүхдүүд анхан шатны дэглэмийн тунгуудыг хийлгэх хоорондоо дараах анхан шатны тунгийн аль нэгийг хийлгэх боломжтой: (1) 5-11 настай хүүхдэд хэрэглэхийг зөвшөөрсөн Пфайзер-БионТек КОВИД-19 вакцин; (2) КОМИРНАТИ (КОВИД-19 Вакцин, мРНХ) эсвэл - 12 ба түүнээс дээш настай хүмүүст хэрэглэх Пфайзер-БионТек КОВИД-19 вакцин.

Пфайзер-БионТек КОВИД-19 вакцин нь ХЭЗ-аас ЯХЗ-ыг доорх нөхцөлтэй хүлээн авсан:

- **анхан шатны цуврал тун хийлгэсэн 5-аас 11 настай хүүхдэд анхан шатны вакцинжуулалтыг зөвшөөрөгдсөн эсвэл батлагдсан КОВИД-19 вакцины анхан шатны вакцин хийлгэж дууссанаас хойш 2 сарын дараа**
- **зөвшөөрөгдсөн эсвэл батлагдсан моновалент⁵ КОВИД-19 вакцины хамгийн сүүлийн нэмэлт тун хийлгэсэн 5-аас 11 настай хүүхдүүдэд хамгийн багадаа 2 сарын дараа нэмэлт нэг тун хийх.**

Энэхүү Вакцины Мэдээллийн Хуудас нь танд өнөөгийн КОВИД-19 цар тахлын улмаас та хийлгэж болзошгүй Пфайзер-БионТек КОВИД-19 вакцин болон Пфайзер-Бионтек КОВИД-19, Бивалент вакцины давуу тал, эрсдэлүүдийн талаар ойлгоход туслах мэдээлэл агуулдаг. Хэрвээ танд асуулт үүсвэл та хүүхдийнхээ вакцин нийлүүлэгчтэйгээ ярина уу.

Энэхүү Мэдээллийн Хуудас цаашид шинэчлэгдэх болно. Хамгийн сүүлийн Мэдээллийн Хуудсыг www.cvdvaccine.com-аас үзнэ үү.

ТА БОЛОН ТАНЫ ХҮҮХЭД ЭНЭ ВАКЦИНЫГ ХИЙЛГЭХИЙН ӨМНӨ ТА ЯМАР МЭДЭЭЛЭЛ АВАХ ХЭРЭГТЭЙ ВЭ

КОВИД-19 ГЭЖ ЮУ ВЭ?

КОВИД-19 өвчин нь SARS-CoV-2 гэх коронавирусаар тардаг халдвартай өвчин. Та вирус тээж буй хүнтэй харьцсанаар КОВИД-19-ийн халдвар авч болзошгүй. Энэ бол ихэвчлэн бусад эрхтэнүүдэд нөлөөлж болзошгүй амьсгалын замын өвчин юм. КОВИД-19-ээр өвдсөн хүмүүст өргөн хүрээний шинж тэмдэгүүд илэрдэг ба дундаж зэргээс маш хүнд шинж тэмдэг илэрч, үхэлд ч хүргэж болдог. Вирусын халдвар авснаас хойш 2-оос 14 хоногийн дараа шинж тэмдэг илэрч болно. Шинж тэмдгүүд доорхийг нэгтгэнэ: халуурах; бие арзайх; ханиах; амьсгалахад хүндрэлтэй болох; ядрах; булчин ба бие өвдөх; толгой өвдөх; үнэртэх болон амтлах чадвараа алдах; хоолой хөндүүрлэх; хамар битүүрэх; нус гоожих; дотор муухайрах; бөөлжих; гүйлгэх.

ПФАЙЗЕР-БИОНТЕК КОВИД-19 ВАКЦИН БОЛОН ПФАЙЗЕР-БИОНТЕК КОВИД-19, БИВАЛЕНТ ВАКЦИН ХООРОНДОО ХЭРХЭН ХОЛБОГДДОГ ВЭ?

Пфайзер-БионТек КОВИД-19, Бивалент вакцин нь адил аргаар хийгдсэн Пфайзер-БионТек КОВИД-19 вакцин нь SARS-CoV-2 Омикрон хувилбараас үүдэлтэй КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх Омикрон бүрэлдэхүүн хэсгийг агуулдаг.

ЯХЗ-ийн дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд Мэдээллийн Хуудасны төгсгөлд буй **“Яаралтай хэрэглэх зөвшөөрөл (EUA) гэж юу вэ?”** хэсгийг үзнэ үү.

⁵Моновалент гэдэг нь зөвхөн анхны SARS-CoV-2-ын баяжуулалтын уураг агуулсан эсвэл кодолсон аливаа зөвшөөрөгдсөн буюу батлагдсан КОВИД-19 вакциныг хэлнэ.

ТА БОЛОН ТАНЫ ХҮҮХЭД ЭДГЭЭР ВАКЦИНЫ АЛЬ НЭГИЙГ ХИЙЛГЭХЭЭС ӨМНӨ ВАКЦИН НИЙЛҮҮЛЭГЧДЭЭ ЮУГ МЭДЭЭЛЭХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

Та вакцин нийлүүлэгчдээ өөрийнхөө хүүхдийн эрүүл мэндийн байдлын тухай, доорхыг оруулан мэдэгдэнэ:

- ямар нэгэн харшилтай
- өмнө нь миокардит (зүрхний булчингийн үрэвсэл) эсвэл перикардит (зүрхний гаднах бүрхүүлийн үрэвсэл) зэрэг өвчнөөр өвдөж байсан эсэх
- халуурч байгаа
- цус алдалтын эмгэгтэй эсвэл цус шингэлэгч эм хэрэглэдэг
- дархлаа суларсан эсвэл таны дархлааны тогтолцоог өөрчлөх эм хэрэглэдэг
- жирэмсэн эсэх
- хөхүүл
- өөр ямар нэгэн КОВИД-19-ийн вакцин хийлгэсэн
- тарилгаас шалтгаалан ухаан алдаж байсан

ЭДГЭЭР ВАКЦИНЫГ ХЭРХЭН ХИЙХ ВЭ?

Пфайзер-БиоНТек КОВИД-19 вакцин болон Пфайзер-Бионтек КОВИД-19, Бивалент вакциныг танд эсвэл таны хүүхдэд булчинд тарих хэлбэрээр хийнэ.

Анхан шатны цуврал: Пфайзер-БиоНТек КОВИД-19 вакциныг анхан шатны цуврал тунгаар хийнэ. Вакциныг 2 цуврал тунгаар, 3 долоо хоногийн зайтай хийнэ. Зарим төрлийн дархлаа султай хүмүүст хоёр дахь тунгаас хойш дор хаяж 28 хоногийн дараа анхан шатны гурав дахь тунг хийж болно.

Нэмэлт тун:

Пфайзер-БиоНТек КОВИД-19, Бивалент вакциныг нэг удаагийн нэмэлт тунгаар дор хаяж 2 сарын дараа хэрэглэнэ:

- зөвшөөрөгдсөн эсвэл батлагдсан КОВИД-19 вакцины анхан шатны вакцинжуулалтад хамрагдсан;
- зөвшөөрөгдсөн эсвэл батлагдсан моновалент КОВИД-19 вакцины хамгийн сүүлийн нэмэлт тунг хийлгэсэн.

Вакцин нь хүн бүрийг хамгаалахгүй байж болно.

ПФАЙЗЕР-БИОНТЕК КОВИД-19 ВАКЦИН, ПФАЙЗЕР-БИОНТЕК КОВИД-19, БИВАЛЕНТ ВАКЦИНЫГ ХЭН ХИЙЛГЭЖ БОЛОХГҮЙ ВЭ?

Доорх тохиолдлуудад таны хүүхдийг вакцинд хамруулахгүй:

- Пфайзер-БиоНТек КОВИД-19 вакцины өмнөх тунг хийлгэсний дараа хүнд хэлбэрийн харшлын урвал үзүүлсэн.
- эдгээр вакцины аль нэг найрлагад хүчтэй харшлын урвал үзүүлсэн.

ЭДГЭЭР ВАКЦИНЫ НАЙРЛАГАД ЯМАР БОДИСУУД ОРСОН БЭ?

Пфайзер-БиоНТек КОВИД-19 вакцин нь доорх найрлагатай: мРНХ, өөх тосууд ((4-гидроксипутил)азанедиил)бис(гексан-6,1-диил)бис(2-гексилдеканат), 2 [(полиэтиленены гликол)-2000]-N,N-дитетрадецилацетамид, 1,2-Дистеароил-сн-глицеро-3-фосфохолин,

ба холестерол), трометамин, трометамины гидрохлорид, сахароз ба натрийн хлорид.

ЭДГЭЭР ВАКЦИНЫГ ӨМНӨ НЬ ХИЙЖ БАЙСАН УУ?

Клиникийн тандалт судалгаанаас үзэхэд, 5-аас 11 насны ойролцоогоор 3,100 хүн Пфайзер-БиоНТек КОВИД-19 Вакцины дор хаяж 1 тунг хийлгэсэн байна. 2020 оны 12-р сарын 11-ээс хойш хэдэн сая хүн ЯХЗ-ийн дагуу Пфайзер-БиоНТек КОВИД-19 вакцинд хамрагдсан.

Клиник тандалтаар 55 ба түүнээс дээш насны ойролцоогоор 300 хүн Пфайзер-БиоНТек КОВИД-19, Бивалент вакцинаас Омекрон бүрэлдэхүүнтэй гэдгээрээ ялгаатай бивалент вакцины 1 тунг хийлгэсэн.

ЭДГЭЭР ВАКЦИНЫ АШИГ ТУС НЬ ЮУ ВЭ?

Пфайзер-БиоНТек КОВИД-19 вакцин нь КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлдэг болохыг тогтоосон. ХЭЗ нь SARS-CoV-2-ын Омикрон хувилбараас үүдэлтэй КОВИД-19-өөс илүү сайн хамгаалахын тулд Пфайзер-БиоНТек КОВИД-19, Бивалент вакциныг зөвшөөрсөн.

КОВИД-19-ээс хамгаалах чадвар үргэлжлэх хугацаа тодорхой бус байна.

ЭДГЭЭР ВАКЦИНЫ ЭРСДЭЛ ЮУ ВЭ?

Эдгээр вакцин нь хүнд хэлбэрийн харшлын урвал үүсгэх магадлал багатай. Хүнд хэлбэрийн харшлын хүнд урвал нь вакцины тунг хийлгэсний дараа хэдэн минутаас нэг цагийн дотор илэрнэ. Энэ шалтгаанаар хүүхдийн вакцин нийлүүлэгч таны хүүхдээс вакцин хийлгэсний дараа түүний биеийн байдлыг хянахаар тус байранд хэсэг хугацаанд үлдэхийг шаардах болно. Хүнд хэлбэрийн харшлын урвалын шинж тэмдэг доорхыг оруулна:

- Амьсгалахад хүндрэлтэй болох
- Нүүр, хоолой хавагнах
- Зүрх хурдан цохилох
- Биеийн бүх хэсэгт тууралт гарах
- Толгой эргэх ба сульдах

Пфайзер-БиоНТек КОВИД-19 вакцин болон Пфайзер-БиоНТек КОВИД-19, Бивалент вакциныг хийлгэсэн зарим хүмүүс миокардит (зүрхний булчингийн үрэвсэл) эсвэл перикардитаар (зүрхний гаднах салст бүрхүүлийн үрэвсэл) өвдсөн. Энэ хүмүүсийн ихэнхэд нь вакцины хоёр дахь тунг хийлгэснээс хойш хэдхэн хоногийн дотор шинж тэмдэг илэрч эхэлсэн. Ийм тохиолдол үүсэх магадлал маш бага. Хэрвээ таны хүүхдэд вакцин хийлгэсний дараа доорх шинж тэмдгүүдийн аль нэг нь илэрвэл эмчид хандана уу:

- Цээжээр өвдөх
- Амьсгал давчдах
- Зүрх хурдан, жигд бус, дэлсэх мэдрэмж төрөх

Эдгээр вакцины мэдэгдэж буй сөрөг нөлөөнүүдэд дараах зүйлс багтана:

- Хүнд хэлбэрийн харшлын урвал
- Тууралт, загатналт, улайлт, чонон хөрвөс, нүүр хавагнах зэргийн хүнд бус харшлын урвалууд
- Миокардит (зүрхний булчингийн үрэвсэл)
- Перикардит (зүрхний гадна талын салст бүрхэвчийн үрэвсэл)

- Тарьсан хэсэгт өвдөх
- Ядрах
- Толгой өвдөх
- Булчингаар өвдөх
- Бие арзагнах
- Үе мөч өвдөх
- Халуурах
- Тарьсан хэсэгт хавдах
- Тарьсан хэсэгт улайх
- Дотор муухайрах
- Бие эвгүйрэх
- Тунгалгийн булчирхай хавдах (лимфаденопати)
- Хоолны дуршил буурах
- Гүйлгэх
- Бөөлжих
- Гар өвдөх
- Вакцин хийлгэсэнтэй холбоотойгоор ухаан алдах
- Толгой эргэх

Эдгээр нь вакцины бүх байж болох сөрөг нөлөө биш ч байж болно. Ноцтой ба гэнэтийн сөрөг нөлөө үүсэж болзошгүй. Эдгээр вакцины сөрөг нөлөөг судалж байгаа хэвээр байна.

СӨРӨГ НӨЛӨӨ ҮҮССЭН ТОХИОЛДОЛД БИ ЮУ ХИЙХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Хэрвээ таны хүүхдэд хүнд хэлбэрийн харшлын урвал илэрвэл 9-1-1 утас руу залгах эсвэл хамгийн ойрын эмнэлэгт хандана уу.

Хэрэв таны хүүхдийн сөрөг нөлөө арилахгүй хэвээр байгаа бол вакцин хийлгэсэн байгууллага эсвэл эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ холбогдоно уу.

Вакцины гадны нөлөөг FDA/CDC Вакцины Сөрөг Нөлөө Мэдээллэх Тогтолцоонд (VAERS) мэдээллэнэ үү. ВСНМС-ийн 1-800-822-7967 үнэгүй утасны дугаар эсвэл <https://vaers.hhs.gov/reportevent.html> вебсайтад онлайн горимд мэдээлнэ үү. Тайлагналын маягтын #18 хайрцагийн эхний шугамд "ЯХЗ-тэй Пфайзер-БиоНТек КОВИД-19 вакцин" эсвэл "ЯХЗ-тэй Пфайзер-БиоНТек КОВИД-19, Бивалент вакцин" гэж оруулна уу.

Үүний зэрэгцээ та сөрөг нөлөөний тухай доорх дугааруудаар Pfizer Inc-т шууд мэдэгдэж болно.

Вебсайт	Факсын дугаар	Утасны дугаар
www.pfizersafetyreporting.com	1-866-635-8337	1-800-438-1985

Танд мөн адил v-safe-д оролцох бас нэгэн сонголт бий. V-safe нь КОВИД-19 вакцин хийлгэсний дараа гарч болзошгүй сөрөг нөлөөг тодорхойлохын тулд вакцин хийлгэсэн

хүмүүст мессеж илгээх, веб судалгаа ашигладаг ухаалаг гар утсанд суурилсан хэрэгсэл юм. V-safe нь COVID-19-ийн вакцинуудын аюулгүй байдлыг хянахаар CDC мониторинг дэм болохоор асуултууд асуудаг. V-safe нь танд хоёр дахь тун хийлгэх тухай санамж явуулах ба хэрвээ оролцогсод COVID-19 вакцинжуулалтын дараа ноцтой сөрөг нөлөө үзүүлсэн бол тэднийг CDC-ийн шууд утсаар хянах боломж олгодог. Дэлгэрэнгүй мэдээлэл авахаар www.cdc.gov/vsafe вебсайтад хандана уу.

ХЭРВЭЭ БИ ХҮҮХЭДДЭЭ ПФАЙЗЕР-БИОНТЕК COVID-19 ВАКЦИН ЭСВЭЛ ПФАЙЗЕР-БИОНТЕК COVID-19, БИВАЛЕНТ ВАКЦИН ХИЙЛГЭХГҮЙ ГЭЖ ШИЙДСЭН БОЛ ЯАХ ВЭ?

ЯХЗ-ийн дагуу та эдгээр вакцины алинд нь хамрагдах эсвэл татгалзах эсэхээ өөрөө шийднэ. Та хүүхдэдээ эдгээр вакцины аль нэгийг хийлгэхгүй гэж шийдсэн бол энэ нь таны хүүхдэд үзүүлэх стандарт эмнэлгийн тусламжид өөрчлөлт оруулахгүй.

ПФАЙЗЕР-БИОНТЕК COVID-19 ВАКЦИН, ПФАЙЗЕР-БИОНТЕК COVID-19, БИВАЛЕНТ ВАКЦИНААС ӨӨР COVID-19-ЭЭС ХАМГААЛАХ ӨӨР СОНГОЛТ БАЙДАГ УУ?

SARS-CoV-2-ын Омикрон бүрэлдэхүүнийг агуулсан бивалент вакцин зэрэг COVID-19-өөс урьдчилан сэргийлэх бусад вакцинуудыг ЯХЗ-ийн хүрээнд хийлгэх боломжтой.

БИ ХҮҮХЭДЭЭ ПФАЙЗЕР-БИОНТЕК COVID-19 ВАКЦИН, ПФАЙЗЕР-БИОНТЕК COVID-19, БИВАЛЕНТ ВАКЦИНЫГ БУСАД ВАКЦИНУУДАЙ ХАМТ ХИЙЛГЭЖ БОЛОХ УУ?

Пфайзер БионТек COVID-19 вакцин эсвэл Пфайзер БионТек COVID-19, Бивалент вакциныг бусад вакцинуудтай хамт хэрэглэсэн мэдээлэл FDA-д одоогоор байхгүй. Хэрэв та хүүхдэдээ

Пфайзер-БионТек COVID-19 вакцин, Пфайзер-БионТек COVID-19, Бивалент вакциныг бусад вакцинуудтай хамт хэрэглэх хүсэлтэй бол хариуцсан эрүүл мэндийн ажилтантайгаа ярилцана уу.

ХЭРЭВ МИНИЙ ХҮҮХЭД ДАРХЛАА СУЛТАЙ БОЛ ЯАХ ВЭ?

Хэрэв таны хүүхэд дархлаа султай бол та хүүхдэдээ Пфайзер-БионТек COVID-19 вакцины анхан шатны гурав дахь тунг хийлгэх сонголт хийх боломжтой.

5-аас 11 насны хүүхдүүд Пфайзер-БионТек COVID-19, Бивалент вакцины нэмэлт нэг тунг хийлгэх боломжтой. Вакцинжуулалт нь дархлаа султай хүмүүст COVID-19-ийн бүрэн дархлаа тогтоохгүй байж болзошгүй тул та өөрийгөө болон хүүхдээ COVID-19-өөс урьдчилан сэргийлэхийн тулд бодит арга хэмжээг үргэлжлүүлэх хэрэгтэй. Мөн таны хүүхдийн ойрын хүмүүс зохих ёсоор вакцин хийлгэх ёстой.

ЖИРЭМСЭН ЭСВЭЛ ХӨХҮҮЛ БОЛ ЯАХ ВЭ?

Хэрэв та жирэмсэн эсвэл хөхүүл бол эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ сонголтынхоо тухай ярилцаарай.

ЭДГЭЭР ВАКЦИН МИНИЙ ХҮҮХЭД COVID-19 ХАЛДААХ УУ?

Үгүй. Эдгээр вакцин нь SARS-CoV-2-ыг агуулдаггүй тул таны хүүхдэд COVID-19 халдаахгүй.

ХҮҮХДИЙНХЭЭ ВАКЦИНЖУУЛАЛТЫН КАРТАА ХАДГАЛНА УУ


Таны хүүхэд COVID-19 вакцины эхний тун хийлгэхэд вакцины карт олгоно. Хүүхэд буцаж ирэхдээ картаа авч ирэхийг санаарай.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Хэрэв танд асууж лавлах зүйл байвал вебсайтад зочлох эсвэл доорх утсаар

холбогдоно уу. Хамгийн сүүлийн Мэдээллийн Хуудаст орохын тулд доорх QR

кодын скан хийнэ үү.

Глобал Вебсайт	Утасны дугаар
<p>www.cvdvaccine.com</p> 	<p>1-877-829-2619 (1-877-VAX-CO19)</p>

БИ ХЭРХЭН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ ВЭ?

- Вакцин нийлүүлэгчээс лавлаж асууна уу.
- Холбоосын дагуу CDC-тай холбогдоно уу <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/index.html>.
- Холбоосын дагуу FDA-тай холбогдоно уу <https://www.fda.gov/emergency-preparedness-and-response/mcm-legal-regulatory-and-policy-framework/emergency-use-authorization>.
- Орон нутгийн эсвэл мужийнхаа эрүүл мэндийн хэлтэстэй холбогдоно уу.

МИНИЙ ХҮҮХДИЙН ВАКЦИНЖУУЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ ХААНА ХАДГАЛАГДАХ ВЭ?

Вакцин нийлүүлэгч нь таны хүүхдийн вакцинжуулалтын мэдээллийг танай муж/орон нутгийн харъяа Дархлаажуулалтын Мэдээллийн Тогтолцоо (IIS) эсвэл бусад тусгай тогтолцоонд оруулна. IIS-ийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл авахаар <https://www.cdc.gov/vaccines/programs/iis/about.html>.-д хандана уу.

БИ ЭДГЭЭР КОВИД-19 ВАКЦИН ХИЙЛГЭСНЭЭР ЗАХИРГААНЫ ТӨЛБӨР ТӨЛӨХ ҮҮ?

Үгүй. Энэ удаа нийлүүлэгч танаас вакцины тунгийн төлбөр авахгүй бөгөөд та зөвхөн КОВИД-19 вакцин хийлгэсэн тохиолдолд вакцин хийлгэсэн болон бусад хураамжийг танаар төлүүлэхгүй. Гэхдээ вакцин нийлүүлэгчид вакцин хүлээн авагчид (хувийн даатгал, Медика, Медикайд, даатгалгүй хүлээн авагчдад зориулсан Даатгалгүй Хөтөлбөр, аливаа нэгэн хөтөлбөр (HRSA) Хүний Нөөц ба Үйлчилгээний захиргаа гэх мэт) эсвэл КОВИД-19-ийн вакцин хийсэн төлбөрийг танд буцаан олгох арга хайж болно.

БИ ЗАЛИЛИНГИЙН СЭЖИГТЭЙ ТОХИОЛДЛЫГ ХААНА МЭДЭЭЛЭХ ВЭ?

CDC COVID-19 Вакцинжуулалтын Хөтөлбөрийг аливаа нэгэн байдлаар зөрчсөн тухай мэдлэг авсан хүмүүс үүнийг Ерөнхий Хянан Шалгах Офис, АНУ-ын Эрүүл Мэндийн ба Хүний Нөөцийн Үйлчилгээний Хэлтэст хандаж, 1-800-HHS-TIPS утсаар мэдээлэх 1-800-HHS-TIPS or <https://TIPS.HHS.GOV>.

ГЭМТЭЛ НӨХӨН БАРАГДУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙН АРГА ХЭМЖЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

Хохирлын нөхөн төлбөрийн хөтөлбөр (CICP) нь тодорхой эм, вакцин, түүний дотор эдгээр вакцинаас болж ноцтой хохирсон хүмүүсийн эмчилгээний зардал, бусад тодорхой зардлуудыг нөхөн төлөхөд туслах холбооны

хөтөлбөр юм. Ерөнхийдөө вакцин хийлгэснээс нэг (1) жилийн дотор C1CP-т өргөдөл гаргах ёстой. Энэхүү хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.hrsa.gov/cicp/ **вебсайт** эсвэл 1-855-266-2427 утсаар холбогдоно уу.

ЯАРАЛТАЙ ХЭРЭГЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ГЭЖ ЮУ ВЭ (EUA)?

Яаралтай Хэрэглээний Зөвшөөрөл (EUA) гэдэг нь КОВИД-19 тар тахал зэрэг нийтийн эрүүл мэндийн онцгой байдлын үед вакцин гэх мэт эрүүл мэндийн бүтээгдэхүүний олдоц, ашиглах боломжийг хөнгөвчлөх механизм юм. EUA нь Эрүүл Мэндийн Алба ба Хүний Үйлчилгээ (HHS)-ээс дэмжигддэг ба КОВИД-19 цар тахлын үед биологийн ба эмийн бүтээгдэхүүнүүдийг яаралтай хэрэглэх баталгааг гаргадаг. Яаралтай хэрэглэх зөвшөөрөл авсан бүтээгдэхүүн нь FDA-аас зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүнтэй адил төрлийн FDA-н хяналтад хамрагдаагүй FDA-аас зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн.

АНУ-ын ХЭЧХГ нь өөр ямар нэгэн адил төстэй, батлагдсан, боломжит хувилбар байхгүй гэсэн тодорхой шалгуурыг хангасан тохиолдолд ЯХЗ олгоно. Мөн түүнчлэн АНУ-ын ХЭЧХГ-ын шийдвэр уг бүтээгдэхүүн КОВИД-19 цар тахлын үеэр КОВИД-19-өөс сэргийлэхэд үр дүнтэй, мөн тухайн бүтээгдэхүүний мэдэгдэж байгаа болон боломжит үр дүн нь мэдэгдэж байгаа болон болзошгүй эрсдэлээс илүү их нөлөөтэй гэдгийг шинжлэх ухааны бүх нотолгоонд үндэслэсэн байна. Бүтээгдэхүүнийг КОВИД-19 цар тахлын үед ашиглахын тулд эдгээр бүх шалгуурыг хангасан байх ёстой.

ЯХЗ нь бүтээгдэхүүнийг цуцлах эсвэл хүчингүй болгохоос бусад тохиолдолд (үүний дараа бүтээгдэхүүнийг цаашид ашиглахгүй) яаралтай хэрэглэхийг зөвшөөрсөн КОВИД-19-ийн мэдэгдлийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

BIONTECH

Үйлдвэрлэсэн
BioNTech Manufacturing GmbH
An der Goldgrube 12
55131 Mainz, Germany



Үйлдвэрлэсэн
Пфайзер Inc., Нью Йорк хот, NY 10017

LAB-1486-8.3c

Хянасан: 22 оны 12-р сарын 8



Энэхүү Мэдээллийн Хүүдсыг вакцинд хамарсан хүмүүсийн эрүүл мэндийн цахим бүртгэл/дархлаажуулалтын мэдээллийн тогтолцоонд оруулсныг батлахаар сканхийж үзнэ үү.